



МОНГОЛ АЛТ ХК

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2024 оны 06 сарын 27-ны өдөр

№ 01

Дархан хот

Хувьцаа эзэмшигчдийн хурал 2026 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 10:15 цагт “Монгол Алт” ХК-ийн офисын хурлын танхимд эхлэв.

Хурлын ирц:

Хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцийн бүртгэлд хувьцаа эзэмшигч Л.Амарсанаа, Л.Базарсад, Б.Саруул, М.Цолмон, А.Болор-Эрдэнэ, Б.Батром, М.Оюун, Ж.Мөнхтөр, А.Молор-Эрдэнэ нар бүртгүүлэн хуралд оролцов.

Компанийн нийт энгийн 265852 ширхэг хувьцаанаас 194613 ширхэг энгийн хувьцааг эзэмшигчид буюу 73,2 хувийн ирцтэйгээр хурал эхлэв.

Л.Амарсанаа: - Та бүхэнд энэ өдрийн мэндийг дэвшүүлье. “Монгол Алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 16-ны өдрийн хурлаар Хувьцаа эзэмшигчдийн хурлыг удирдуулахаар намайг сонгосон байна.

Өнөөдрийн хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, дотоод журмыг танилцуулж батлуулъя.

Нэгдүгээрт, Компанийн 2025 оны санхүүгийн тайлан,

Хоёрдугаарт, ТУЗ-ийн хараат бус гишүүдийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэнэ,

Гуравдугаарт, Ногдол ашиг хуваарилах тухай,

Дөрөвдүгээрт, ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох тухай,

Тавдугаарт, ТУЗ-ийн 2026 оны зардлын төсөв, ТУЗ-ийн дарга, гишүүдийн урамшууллын хэмжээг батлах тухай зэрэг болно.

Хэлэлцэх асуудлыг батлахыг зөвшөөрч байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Хуралдаанд оролцож байгаа хувьцаа эзэмшигчид бүрэн зөвшөөрлөө.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэгийг танилцуулъя.

Асуудал хэлэлцэх журам. Санхүүгийн тайлангийн танилцуулга, нягтлан бодогч Ж.Мягмарцэцэг танилцуулна, хугацаа 10 минут. ТУЗ-ийн хараат бус гишүүдийн дүгнэлт, ТУЗ-ийн хараат бус гишүүн О.Лувсаншарав танилцуулна, хугацаа 10 минут. Ногдол ашиг хуваарилах санал Гүйцэтгэх захирал М.Цолмон танилцуулна, хугацаа 10 минут, ТУЗ-ийн гишүүдийг сонгох асуудал, нэр дэвшигчдийг танилцуулах хугацаа 10 минут. Хэлэлцүүлэг, асуулт, хариулт, хувьцаа эзэмшигч бүр 5 хүртэл минут.

ХЭЛЭЛЦСЭН нь:

- Эхний асуудлаа хэлэлцье. Компанийн 2025 оны санхүүгийн тайланг сонсож хэлэлцэнэ. Ерөнхий нягтлан бодогч Ж.Мягмаа чөлөөтэй байгаа учир нягтлан бодогч Ж.Мягмарцэцэг танилцуулна.

Ж.Мягмарцэцэг:- Санхүүгийн дэлгэрэнгүй тайланг уншиж танилцуулъя. “Монгол Алт” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланг танилцуулъя. Манай компанийн санхүү тайлант онд орон сууцны барилгын борлуулалтын орлого, түрээсийн орлого, улсын төсвийн санхүүжилтээр гүйцэтгэж байгаа ажлын орлогоос бүрдсэн.

Санхүүгийн тайлангийн дэлгэрэнгүй задаргааг уншиж танилцуулав. (Дэлгэрэнгүйг Хурлын материалд хавсаргав).

Л.Амарсанаа: - “Монгол Алт” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлангийн танилцуулга хийсэн Ж.Мягмарцэцэгт баярлалаа.

Нийт асуудлуудаа хэлэлцчихээд дараа нь асуулт, хариултаа явуулъя гэсэн саналтай байна.

Хоёрдугаарт, “Монгол Алт” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн хараат бус гишүүдийн дүгнэлтийг хараат бус гишүүн О.Лувсаншарав танилцуулна.

О.Лувсаншарав:- Санхүүгийн тайланг сонслоо. Дэлгэрэнгүй тайлан байна. Задаргаатайгаа нарийн гаргасан тайлан байна. Хараат бус гишүүдийн дүгнэлтийг уншиж танилцуулъя.

Санхүүгийн тайланд хийсэн хараат бус гишүүдийн дүгнэлтийг уншиж танилцуулав. (Дэлгэрэнгүйг Хурлын материалд хавсаргав).

Л.Амарсанаа: - Хараат бус гишүүдийн дүгнэлтийг танилцуулсан О.Лувсаншаравт баярлалаа.

Дараагийн асуудал ногдол ашиг хуваарилах тухай асуудлыг М.Цолмон танилцуулна.

М.Цолмон: - Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаанд хүрэлцэн ирсэн нийт хувьцаа эзэмшигчдэд энэ өдрийн мэндийг дэвшүүлье.

Ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр Төлөөлөн Удирдах Зөвлөлийн тогтоолоор гарчихдаг. Хувьцаа эзэмшигчдийн хурал болохоос өмнө гардаг. Энэ жилийн компанийн үйл ажиллагаа 200 гаруй сая төгрөгийн ашигтай гарсан учраас, өнгөрсөн жилийн нэгж хувьцаанд олгогдож байсан үнийн дүнг бага зэрэг өсгөөд 500 төгрөг хуваарилана. Ингэснээр 132 сая 926 мянган төгрөгийг хуваарилана. Энэхүү шийдвэр нь компанийн санхүүгийн тогтвортой байдалд сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд хувьцаа эзэмшигчдийн итгэлийг бэхжүүлэх, цаашдын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг хэвийн үргэлжлүүлэх бүрэн боломжтой гэж үзсэн.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийг үндэслэн ногдол ашиг хуваарилах тухай тогтоолын төслийг хэлэлцэн баталж өгөхийг хүсч байна.

Л.Амарсанаа: - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн энгийн гишүүн болон хараат бус гишүүнээр нэр дэвшсэн хүмүүсийг М.Цолмон танилцуулна.

М.Цолмон: - “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгохоор тогтсон. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр Л.Амарсанаа, М.Цолмон, М.Оюун, Ж.Мөнхтөр, А.Болор-Эрдэнэ, Б.Саруул

нар, хараат бус гишүүнээр О.Лувсаншарав, С.Дорждэрэм, Б.Базарсад нарын нэрийг дэвшүүлж байгаа болно.

Өмнөх бүрэлдэхүүнээс Б.Цэлмэг, А.Молор-Эрдэнэ нар ажлын шаардлагаар үүргэлжлүүлэн ажиллах боломжгүй болсон.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн урамшууллын хэмжээнд өөрчлөлт оруулаагүй байгаа. Өмнө нь дарга 200 мянган төгрөг, гишүүд 180 мянган төгрөг, нарийн бичгийн дарга 120 мянган төгрөгийн сарын урамшуулалтай, нийт төсөв нь 21,120,000.0 төгрөгийн хэмжээтэй байгаа.

Энэ хэмжээгээр нь баталж өгнө үү.

Л.Амарсанаа: - Хэлэлцэхээр төлөвлөсөн асуудлуудаас 4 асуудал танилцуулагдаж дууслаа. Асуудлуудтай холбогдуулж асуух асуулт байна уу?

М.Оюун: - Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдэд асууж тодруулах зүйл байна уу?

Б.Батром: - Өмнө 200 мянганы зураглалаар ажил сайн хийгдсэн. Манай компанийн авсан геологийн судалгааны ажлыг гайгүй гүйцэтгэх байх гэж бодож байна.

Л.Амарсанаа: - Агаарын зураглал хийгдэх юм байна. Тийм үү?

Б.Батром: - Агаарын зураглалыг манай орон урьд нь бүрэн хийсэн юм. Тэр бүх гэрэл зураг архивт байдаг. Сансрын зургийг бид өөрсдийн хэмжээнд интернетээс аваад байгаа. Зургийн чанар сайн.

Миний хувьд хэдэн жил чөлөөтэй байлаа. Одоо та ажиллаарай гэвэл ажиллана.

М.Оюун: - "Момо агро" ХХК-ийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар шийдвэр гаргах шаардлагатай гэж үзэж байна.

Л.Амарсанаа: - "Момо агро" ХХК-ийн талаар шийдвэр гаргах санал боловсруулж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хуралд танилцуулан шийдвэрлүүлэхийг М.Цолмон захиралд хариуцуулж байна.

Хувьцаа эзэмшигчдэд асуух асуулт байна уу? Байхгүй. Асуулт тасаллаа. Санал хэлэх хүн байвал сонсьё.

Б.Батром: - Барилгын ажил дээр манай компани харьцангуй туршлага суулаа гэж би ойлгож байгаа. Барилга барьсан байхад борлогдохгүй байна гэсэн зүйл манайд байхгүй юм байна. Хамгийн чухал нь чанартай барих хэрэгтэй. Хүмүүс чанарт маш их анхаардаг болжээ.

Сургуулийн хувьд ашиг ихгүй ч гэсэн боловсролын үйл ажиллагаа явуулахад буруу зүйл байхгүй. Нэр хүндийн асуудал юм. Ийм л бодолтой байна.

М.Оюун: - Сүүлийн үед багш нарын цалин хөлсний асуудлаар төрөөс огцом шийдвэр гаргадаг асуудал хүндрүүлж байгаа. Гэхдээ нэмэгдсэн хэмжээнд хүргээд, түүнээс арай дээр хэмжээнд барьж байгаа. Бас сайн багш нарыг урьж авчирч, тэдний нийгмийн асуудлыг шийдвэрлэж байгаа. Ер нь бол улсынхаа хэмжээнд "Монгол Оюу" сургууль гайгүй явж байгаа. Тийм учраас сургууль боломжийн ажиллаж байна.

Барилгын салбарт бол сайн тооцож, судлах хэрэгтэй. Дарханы маань зах зээл, орон сууцны зах зээл ямар байна? Дахиад орон сууц бариад байх юм уу? Яах вэ? гэх мэт маш сайн судалж байж дараагийнхаа төсөл рүү орсон нь зөв болов уу л гэж бодож байна.

Б.Батром: - Шилжин суурьших хөдөлгөөн их л байна л даа.

М.Оюун: - Тэр хэмжээгээр их барилга баригдаж байна. Бас зах зээл нь ханачихаад байна. Үнийн уналт үүсвэл хэцүү.

О.Лувсаншарав:- Худалдан авах чадвар яг санасан хэмжээнд хүрэхгүй байна. Худалдан борлуулахад урдчилсан захиалга авахад хязгаарлал тавиад эхэллээ.

М.Цолмон:- 2025 оны хурал дээр бид нар “Дулаан апартамент”, “Голден таун” эхний барилгаас ашигтай гарах байх гэж тооцож байсан. Энэ жил бол “Дулаан апартамент”, “Голден таун”-ы барилгаас тус тус 2 тэрбум төгрөгийн ашигтай гарах байх гэж тооцож байна. Бүх зардлаа гаргаад, зээлийн эргэн төлөлтөө хийгээд энэ оны эцсээр 6 тэрбум төгрөгийн ашигтай гарах ёстой. Бага зэрэг хийгдэх ажлууд үлдсэнийг гүйцээгээд.

“Дулаан апартамент” төсөл дээр бага зэрэг санаа зовоож байсан асуудал бол газрын асуудал байсан. Гэхдээ ямар ч байсан “Дарханы Дулааны Сүлжээ” ТӨХК-ийн нэр дээр гарсан байсан газрын захирамж цуцлагдсан. Одоо манай эзэмшилд шилжүүлэх гарц гаргалгаа хайж байгаа. Тэр болчихвол Улсын комисст хүлээлгэн өгөх ажил болчихно.

“Голден таун”-ы ажил яг л графикийн дагуу яваад л байна. Тэгэхээр энэ жилийн эцэс дээр ямар ч байсан ашигтай гарна. Гэхдээ энэ жил ямар барилга эхлүүлэх вэ? гэдэг асуудал маш чухал болчихоод байна.

2027 оны сонгуулийн үеэр зах зээлд мөнгөний нийлүүлэлт нэмэгдэнэ. 2028 оны сонгуулийн үеэр бүр их нэмэгдэнэ. Тэр үед бид нар борлуулах бэлэн барилгатай байж байх ёстой. Тэгэхээр энэ ондоо боломж, бололцоогоо харж байгаад барилга эхлүүлчихмээр л байгаа юм.

Б.Батром: - “Монгол Алт” ХК-ийнхаа хуучин гарааш байгаа шүү дээ. Энэ газраа зөв ашиглах хэрэгтэй.

А.Болор-Эрдэнэ:- Надад нэг санал байна. Цолмон захирлыг мөнгөн шагналаар шагнаж, урамшуулах боломж байгаа юу? Яагаад гэвэл энэ хүн маш их ачааг үүрч, бүх хүчээ дайчилж байгаа. Боломж байвал тийм шийдвэр гаргаж болох уу?

Яг одоо бэлэн мөнгө төгрөгийн хомсдолтой байж болно. Гэхдээ дүйцүүлэх хэмжээнд бас шийдвэрлэж болно.

Л.Амарсанаа: - Ойлголоо. Өөр санал байна уу?

М.Оюун:- Шагнал, урамшуулалтай холбоотой журам байдаг. Би энэ саналыг бол дэмжиж байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр гарах ёстой байх.

Л.Амарсанаа: - Өөр санал байна уу? Санал байхгүй бол тасаллаа.

Гүйцэтгэх захиралд урамшуулал олгох асуудлыг миний хувьд бол дэмжиж байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлаар заавал шийдвэрлэх албагүй биз дээ? Журам байдаг юм байна. Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс шийдвэр гаргах юм байна.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдээ сонгоод шийдвэр гаргахаар тогтлоо.

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар нийтдээ 5 асуудал хэлэлцэхээр оруулсан.

Тооллогын комисс ажилдаа орно уу.

Тооллогын комисс санал хураалтын үйл ажиллагааг зохион байгуулав.

Л.Амарсанаа:- Тооллогын комисс санал хураалтын дүнг гаргаж дууслаа. Тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

Нэгдүгээрт, “Тооллогын комиссын 01 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Монгол алт” ХК-ийн 2025 оны санхүүгийн тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийн тайланг баталсугай.

2.Тус компанийн 2026 оны бизнес төлөвлөгөөг баталж хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг шинээр байгуулагдах Төлөөлөн Удирдах Зөвлөлд, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д тус тус үүрэг болгосугай” гэсэн тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух хувьцаа эзэмшигч байна уу? Асуулт байхгүй байна.

Санал байна уу? Байхгүй байна.

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжлээ.

Хоёр дахь тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Тооллогын комиссын 02 тоот тогтоолыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Ээлжит хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар нэгж хувьцаанд 500 (таван зуун) төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар тогтсугай.

2. Ногдол ашгийг холбогдох журмын дагуу хугацаанд нь олгож, тайланг Хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулахыг Гүйцэтгэх захирал (М.Цолмон)-д даалгасугай” гэсэн тогтоолын төсөл байна. Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух хувьцаа эзэмшигч байна уу? Асуулт байхгүй байна.

Санал байна уу? Байхгүй байна.

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжлээ.

Гурав дахь тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Тооллогын комиссын 03 тоот тогтоолыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас ТОГТООХ нь:

1. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр сонгосугай. Үүнд:

1.1. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүнээр:

1.1.1. Л.Амарсанаа

1.1.2. М.Цолмон

1.1.3. М.Оюун

1.1.4. Ж.Мөнхтөр

1.1.5. А.Болор-Эрдэнэ

1.1.6. Б.Саруул

1.2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнээр:

1.2.1. О.Лувсаншарав

1.2.2. С.Дорждэрэм

1.2.3. Б.Базарсад”.

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийг сонгосон тогтоолын төслийг батлахыг дэмжиж байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух хувьцаа эзэмшигч байна уу? Асуулт байхгүй байна.

Санал байна уу? Байхгүй байна.

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжиж байна.

Дөрөв дэх тогтоолын төслийг уншиж танилцуулъя.

“Тооллогын комиссын 04 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хэвийн үйл ажиллагаа хангах 2026 оны зардлын төсвийг 21,120,000.0 (хорин нэгэн сая нэг зуун хорин мянга) төгрөгөөр тогтоосугай.
2. “Монгол алт” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга, гишүүдийн урамшууллын хэмжээг энэхүү тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсугай” гэсэн тогтоолын төслийг батлахыг дэмжиж байгаа хувьцаа эзэмшигчид гараа өргөнө үү.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух хувьцаа эзэмшигч байна уу? Асуулт байхгүй байна.

Санал байна уу? Байхгүй байна.

Хувьцаа эзэмшигчид бүгд дэмжиж байна.

Тогтоолын төслүүд батлагдлаа.

Би 2025 оны компанийн үйл ажиллагааны талаар товчхон дүгнэлт хийгээд хаая.

Бид бүхэн 2023 оноос үйл ажиллагааныхаа чиглэлд өөрчлөлт оруулж өргөжүүлээд, барилгын төсөл хэрэгжүүлж эхэлсэн. Барилгын төсөл хэрэгжүүлж эхэлснээр нэгдүгээрт, үйл ажиллагаа өргөжсөн. Хоёрдугаарт, ажлын цар хүрээ нэмэгдсэн. Тэр хэмжээгээрээ ажил төрөлд ахиц гарсан.

Тийм учраас энэ ажлыг 2023 оноос сайн удирдан зохион байгуулах үүрэг манай Гүйцэтгэх захирал М.Цолмонд оногдоод явж байгаа. М.Цолмон энэ үүргийг сайн биелүүлж ажиллаж байгаа учраас нийт хувьцаа эзэмшигчид, энэ хуралд оролцож байгаа та бүхнийхээ өмнөөс халуун баяр хүргэж, талархал илэрхийлэх нь зөв болов уу гэж бодож байна.

М.Цолмон:- Баярлалаа.

Л.Амарсанаа: - Цаашдаа урам зоригоороо хамт олноо нягтруулаад, ажил төрлийг нь зөв чиглүүлээд явнаа гэдэгт итгэл дүүрэн байна.

Өнөөдөр хуралдаа идэвхтэй оролцсон хувьцаа эзэмшигч та бүхэндээ талархаж байна.

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
С.Бат-Эрдэнэ

ХЯНАСАН:

ХУРЛЫН ДАРГА Л.АМАРСАНАА

